



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/29

Номгон

Г Хөрөнгө оруулалтын чуулган зохион 7  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/60 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх, Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилгыг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших, үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, хамтран ажиллах, Баянхонгор аймагт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бизнес эрхлэх боломжуудыг танилцуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын татаж, аймаг болон бүс нутгийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэн орон нутагт амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулсугай.

2.Дээрх чуулганд шаардагдах 36,000,000 (Гучин зургаан сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгө оруулалтын чуулганыг чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Батсуурь)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

• 642312017